



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэбулган сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/148/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Архангай аймаг

2022 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Аудитор Л.Соёлмөнх

Цахим хаяг: Soyolmunkhl@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал, дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
3. Аудитын тайлан	8
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Аудитын илрүүлэлт.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн захирагч
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2022.02.25 № 123
танай _____ -ны № _____ -т

ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Э.АНХПҮРЭВ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Э. Анхпүрэв* Т.БАЙГАЛМАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021.12.31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	46,594,940.89	78,237,270.61
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	233,096.23
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	233,096.23
31210	Төгрөг	0.00	233,096.23
31211	Төрийн сангийн харилцах	0.00	233,096.23
33	АВЛАГА	0.00	13,733,200.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	0.00	13,733,200.00
35	БАРАА МАТЕРИАЛ	46,594,940.89	64,270,974.38
35100	Түүхий эд материал	15,880,082.36	24,742,365.73
35130	Эм боох материал	15,880,082.36	24,742,365.73
35400	Хангамжийн материал	30,714,858.53	39,528,608.65
35420	Аж ахуйн материал	16,760,442.00	24,392,721.54
35430	Сэлбэг хэрэгсэл	2,381,216.00	1,440,000.00
35440	Түлш, шатах тослох материал	2,059,850.00	2,100,970.00
35450	Барилгын засварын материал	8,998,000.00	10,448,000.00
35460	Хүнсний материал	515,350.53	1,146,917.11
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	211,342,416.48	247,612,180.51
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	211,342,416.48	247,612,180.51
39200	Биет хөрөнгө	169,393,666.48	204,494,680.51
39201	Барилга, байгууламж, орон сууц	138,464,175.69	138,464,175.69
39202	Хуримтлагдсан элэгдэл	-16,021,292.64	-24,031,938.96
39203	Авто-тээврийн хэрэгсэл	32,700,000.00	32,700,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-5,400,000.00	-10,950,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	65,252,530.98	74,763,827.07
39206	Хуримтлагдсан элэгдэл	-47,832,647.84	-10,757,237.92
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,267,437.10	5,515,554.30
39208	Хуримтлагдсан элэгдэл	-4,036,536.81	-1,209,699.67
39300	Биет бус хөрөнгө	41,948,750.00	43,117,500.00
39301	Програм хангамж	1,787,500.00	1,787,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,168,750.00	0.00
39303	Бусад биет бус хөрөнгө	41,330,000.00	41,330,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	257,937,357.37	325,849,451.12
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	257,937,357.37	325,849,451.12
51	Засгийн газрын хувь оролцоо	257,937,357.37	325,849,451.12
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	225,002,891.67	225,002,891.67
51200	Хуримтлагдсан үр дүн	-22,033,196.38	46,439,485.06
51210	Өмнөх үеийн үр дүн	-23,007,785.23	-21,472,608.69
51220	Тайлант үеийн үр дүн	974,588.85	67,912,093.75
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	54,967,662.08	54,407,074.39
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	257,937,357.37	325,849,451.12

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	291,926,932.16	512,613,563.13
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	28,224,792.16	134,271,943.13
120	Нийтлэг татварын бус орлого	28,224,792.16	134,271,943.13
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	28,224,792.16	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	28,224,792.16	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	54,706,243.37
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	79,565,699.76
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	263,702,140.00	378,341,620.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	244,158,200.00	283,250,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	244,158,200.00	283,250,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,916,700.00	37,283,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,916,700.00	23,550,000.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	0.00	13,733,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	5,403,200.00	6,296,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	5,403,200.00	6,296,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	7,224,040.00	51,511,020.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	7,224,040.00	44,816,800.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	0.00	6,694,220.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	290,952,343.31	444,701,469.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	290,952,343.31	444,701,469.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	290,911,243.88	423,701,469.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	173,507,824.57	235,072,276.77
210101	Үндсэн цалин	116,062,583.58	130,616,586.00
210102	Нэмэгдэл	41,510,316.42	74,655,318.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,934,924.57	0.00
210104	Урамшуулал	12,000,000.00	19,752,362.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	10,048,010.77
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,426,900.00	30,258,715.00
210201	Тэтгэврийн даатгал	16,485,600.00	21,834,115.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,735,300.00	2,106,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,388,200.00	1,684,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	347,100.00	421,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,470,700.00	4,212,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,858,318.00	6,706,850.00
210301	Гэрэл, цахилгаан	1,035,803.00	1,300,124.00
210302	Түлш, халаалт	6,822,515.00	5,256,726.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	150,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,980,890.00	18,643,795.00
210401	Бичиг хэрэг	1,304,850.00	1,671,050.00
210402	Тээвэр, шатахуун	7,949,860.00	9,968,530.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	845,000.00	1,407,880.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,192,540.00	1,327,565.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	53,640.00	1,270,880.00

210408	Бараа материал акталсны зардал	5,635,000.00	2,997,890.00
2105	Нормативт зардал	22,498,281.23	105,703,881.27
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,824,906.91	99,652,057.85
210502	Хоол, хүнс	4,673,374.32	6,051,823.42
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	394,000.00	4,137,616.00
210604	Урсгал засвар	394,000.00	4,137,616.00
2107	Томилолт, зочны зардал	379,000.00	252,000.00
210702	Дотоод албан томилолт	379,000.00	252,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,382,390.00	754,643.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,785,490.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	40,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,000.00	182,643.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	246,900.00	572,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,483,640.08	22,171,692.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,752,931.00	3,735,213.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,730,709.08	18,436,479.34
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,099.43	21,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	21,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	21,000,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	41,099.43	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	41,099.43	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	974,588.85	67,912,093.75
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	974,588.85	67,912,093.75

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	225,002,891.67	54,967,662.08	-23,007,785.23	256,962,768.52
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	225,002,891.67	54,967,662.08	-23,007,785.23	256,962,768.52
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	974,588.85	974,588.85
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	225,002,891.67	54,967,662.08	-22,033,196.38	257,937,357.37
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	225,002,891.67	54,967,662.08	-22,033,196.38	257,937,357.37
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	225,002,891.67	54,967,662.08	-22,033,196.38	257,937,357.37
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	560,587.69	560,587.69
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	-560,587.69	0.00	-560,587.69
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	67,912,093.75	67,912,093.75
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	225,002,891.67	54,407,074.39	46,439,485.06	325,849,451.12

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	263,702,140.00	364,608,420.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	263,702,140.00	364,608,420.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	244,158,200.00	283,250,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	244,158,200.00	283,250,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,916,700.00	68,366,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,916,700.00	68,366,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	5,403,200.00	6,296,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	5,403,200.00	6,296,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	7,224,040.00	6,694,220.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	7,224,040.00	6,694,220.00
II	НИИТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	259,682,340.00	364,375,323.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	259,682,340.00	364,375,323.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	259,641,240.57	343,375,323.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	173,507,824.57	235,072,276.77
210101	Үндсэн цалин	116,062,583.58	130,616,586.00
210102	Нэмэгдэл	41,510,316.42	74,655,318.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,934,924.57	0.00
210104	Урамшуулал	12,000,000.00	19,752,362.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	10,048,010.77
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,426,900.00	30,258,715.00
210201	Тэтгэврийн даатгал	16,485,600.00	21,834,115.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,735,300.00	2,106,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,388,200.00	1,684,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	347,100.00	421,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,470,700.00	4,212,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,972,700.00	7,116,500.00
210301	Гэрэл, цахилгаан	1,022,400.00	1,300,124.00
210302	Түлш, халаалт	4,950,300.00	5,666,376.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	150,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,015,500.00	16,000,000.00
210401	Бичиг хэрэг	1,500,000.00	1,500,000.00
210402	Тээвэр, шатахуун	8,615,500.00	9,600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	800,000.00	1,182,880.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	945,680.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	900,000.00	2,771,440.00
2105	Нормативт зардал	10,882,900.00	38,249,089.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,782,800.00	29,927,089.00
210502	Хоол, хүнс	3,500,100.00	6,722,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,600,000.00	1,600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,690,500.00	9,672,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,260,000.00	8,242,100.00
210604	Урсгал засвар	1,430,500.00	1,430,000.00
2107	Томилот, зочны зардал	379,000.00	252,000.00
210702	Дотоод албан томилот	379,000.00	252,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,625,916.00	754,643.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,029,016.00	0.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	40,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,000.00	119,960.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	246,900.00	634,683.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,140,000.00	6,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,140,000.00	6,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,099.43	21,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	21,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	21,000,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	41,099.43	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	41,099.43	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	4,019,800.00	233,096.23
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	4,019,800.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,019,800.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,019,800.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,019,800.00	0.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-4,019,800.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	233,096.23
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	233,096.23

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	297,446,500.00	296,008,523.77	1,437,976.23	99.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	297,446,500.00	296,008,523.77	1,437,976.23	99.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	297,446,500.00	296,008,523.77	1,437,976.23	99.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	210,616,800.00	210,480,080.77	136,719.23	99.94
210101	Үндсэн цалин	120,000,000.00	130,616,586.00	10,616,586.00	108.85
210102	Нэмэгдэл	44,000,000.00	50,063,122.00	-6,063,122.00	113.78
210104	Урамшуулал	20,185,000.00	19,752,362.00	432,638.00	97.86
210105	Гэрээт ажлын хөлс	26,431,800.00	10,048,010.77	16,383,789.23	38.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,433,200.00	28,433,200.00	0.00	100.00
210201	Тэтгэврийн даатгал	20,008,600.00	20,008,600.00	0.00	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,106,200.00	2,106,200.00	0.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,684,900.00	1,684,900.00	0.00	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	421,200.00	421,200.00	0.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,212,300.00	4,212,300.00	0.00	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,866,500.00	4,866,500.00	0.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	1,380,000.00	1,300,124.00	79,876.00	94.21
210302	Түлш, халаалт	3,336,500.00	3,416,376.00	-79,876.00	102.39
210303	Цэвэр, бохир ус	150,000.00	150,000.00	0.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,000,000.00	16,000,000.00	0.00	100.00
210401	Бичиг хэрэг	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	9,600,000.00	9,600,000.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	800,000.00	1,182,880.00	-382,880.00	147.86
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	945,680.00	254,320.00	78.81
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,900,000.00	2,771,440.00	128,560.00	95.57
2105	Нормативт зардал	22,100,000.00	22,100,000.00	0.00	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,000,000.00	15,000,000.00	0.00	100.00
210502	Хоол, хүнс	5,500,000.00	5,500,000.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,600,000.00	1,600,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,930,000.00	7,122,100.00	807,900.00	89.81
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,500,000.00	5,692,100.00	807,900.00	87.57
210604	Урсгал засвар	1,430,000.00	1,430,000.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	300,000.00	252,000.00	48,000.00	84.00
210702	Дотоод албан томилолт	300,000.00	252,000.00	48,000.00	84.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,200,000.00	754,643.00	445,357.00	62.89
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	0.00	250,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	80,000.00	0.00	80,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,000.00	119,960.00	40.00	99.97
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	750,000.00	634,683.00	115,317.00	84.62
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,000,000.00	6,000,000.00	0.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,000,000.00	6,000,000.00	0.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	297,446,500.00	296,241,620.00	1,204,880.00	99.59
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	283,250,900.00	283,250,900.00	0.00	100.00
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	283,250,900.00	283,250,900.00	0.00	100.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	6,296,500.00	6,296,500.00	0.00	100.00
320001	Орон нутгийн төсвөөс	6,296,500.00	6,296,500.00	0.00	100.00
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	7,899,100.00	6,694,220.00	1,204,880.00	84.75
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	7,899,100.00	6,694,220.00	1,204,880.00	84.75
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	233,096.23	-233,096.23	0.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	15	15	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10	10	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	4	4	0.00	100.00

2.5 Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	68,366,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	68,366,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	47,366,800.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	24,592,196.00
210102	Нэмэгдэл	24,592,196.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,825,515.00
210201	Тэтгэврийн даатгал	1,825,515.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,250,000.00
210302	Түлш, халаалт	2,250,000.00
2105	Нормативт зардал	16,149,089.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,927,089.00
210502	Хоол, хүнс	1,222,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,550,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,550,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	21,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	68,366,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,550,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,550,000.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	44,816,800.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Эрдэнэбулган сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Соёлмөнх гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэбулган сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Эрдэнэбулган сумын Эрүүл мэндийн төв нь Иргэн бүрт чиглэсэн эрүүл мэндийн зөв хэвшил төлөвшүүлэх, сургалт сурталчилгааг зохион байгуулж, хүн амын эрүүл аж төрөх мэдлэг, дадлыг төлөвшүүлэх зорилготой нийгмийн болон эмнэлгийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг хүргэх чиг үүрэг бүхий аймгийн ТЕЗ-ийн харьяа тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага байна.

Тус байгууллага нь тайлант онд иргэдэд эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулж, мэдээ мэдээлэл гарын авлага материалаар хангах зорилтыг тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Нийгмийн даатгалын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-иар нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ өөрчлөгдсөн.
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 67/А/268, А/387/99 дугаар тушаал “Коронавируст халдвар /Ковид-19/-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журам, тусламж үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ батлах тухай”

- Эрүүл мэндийн Сайдын 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/496 дугаар тушаал “Нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгох тухай”
- Эрүүл мэндийн Сайдын 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/605 дугаар тушаал “Журам, аргачлал батлах тухай”
- Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/585 дугаар тушаал “Мөнгөн тэтгэмж олгох тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Эрдэнэбулган сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2021 оны А/06 дугаар тушаалаар дотоод хяналтын багийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан бөгөөд тайлант хугацаанд байгууллагын дотоод хяналт шалгалтын жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулан 8 чиглэлийн хүрээнд дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккурель сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу хөтөлбөр, арга хэмжээгээр бэлтгэж, тайлбар танилцуулгын хамт ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 296.0 сая төгрөгөөс 1 хувиар буюу 2.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 2.2 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн шатны ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 26.3 хувиар өссөн материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өөрчлөлт	хувь
Мөнгөн хөрөнгө	0	0.23	0.23	-
Авлага	0	13.7	13.73	-
Бараа материал	46.59	64.27	17.68	37.95
Үндсэн хөрөнгө	211.34	247.61	36.27	17.16
Нийт хөрөнгө	257.93	325.84	67.91	26.33
Өр төлбөр	0	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	257.93	325.84	67.91	26.33
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	257.93	325.84	67.91	26.33

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл тайлант онд 0.23 сая төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэлээр санхүүжүүлдэг болсонтой холбоотой байна.
- Авлагын дансны үлдэгдэл тайлант онд 13.7 сая төгрөгөөр өссөн нь ЭМДС-аас авах ковидын цогц тусламж үйлчилгээний санхүүжилт нэхэмжилснээс дутуу ирсэнтэй холбоотой байна.
- Бараа материал эхний үлдэгдлээс 37.95 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 46.5 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 73.7 сая төгрөг, хандиваар 79.6 сая төгрөг, нийт 153.3 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 135.6 сая төгрөгийн бараа материалыг зарцуулан оны эцэст 64.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгө эхний үлдэгдлээс 17.1 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 285.8 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд худалдан авсан хөрөнгө байхгүй, Эрүүл мэндийн яамнаас 10.8 сая төгрөгийн, аймгийн Эрүүл мэндийн газраас 1.6 сая төгрөгийн, нийт 12.4 сая төгрөгийн хандив тусламж өгснийг данс бүртгэлд тусгаж, зөвлөмжийн мөрөөр хугацаа сунгаж дахин орлогод авсан 42.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгөөр, нийт 54.7 сая төгрөгөөр нэмэгдэж, 45.9 сая төгрөгөөр хөрөнгийг актлаж данснаас хассан, тайлант хугацаанд байгуулсан 47.0 сая төгрөгийн элэгдлээр буурч, 247.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн 67.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүнтэй шууд холбоотой бөгөөд тайлант хугацаанд 67.9 сая төгрөгийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	28.22	134.27	106.05
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	244.16	283.25	39.09
Нэмэлт санхүүжилт	6.92	37.28	30.36
Орон нутгийн төсвөөс	5.40	6.30	0.90
Эрүүл мэндийн даатгалын сангаас	7.22	51.51	44.29
Үйл ажиллагааны орлого	291.92	512.61	220.69
Цалин, шимтгэлийн зардал	196.92	265.32	68.40
Бараа ажил үйлчилгээний зардал	48.13	135.46	87.33
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24.38	0.75	(23.63)
Бараа үйлчилгээний бусад зардал	21.48	22.17	0.69
Урсгал шилжүүлэг	0.04	21.00	20.96
Хөрөнгийн зардал			-
Үйл ажиллагааны зардал	290.95	444.70	153.75
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	0.97	67.91	66.94

Эрдэнэбулган сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны орлого өмнөх оноос 220.69 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд ковид-19-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээний санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон, мөн үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 374.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 77.2 сая төгрөгөөр бууруулж нийт зардлыг 297.4 сая төгрөгөөр хянаж баталсан бол тодотголоор батлагдсан төсөвт өөрчлөлт ороогүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагч 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 297.4 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 1.2 сая төгрөгийн санхүүжилт Эрүүл мэндийн даатгалын сангаас дутуу авсан байна. Тайлант онд 296.0 сая төгрөгийн санхүүжилтийг авч, бүрэн зарцуулсан бөгөөд мөнгөн хөрөнгийн 0.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Энэ нь Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэлээр санхүүжүүлэх болсонтой холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар ЭМДС-аас ковид-19-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээний санхүүжилт 23.8 сая төгрөг, Эрүүл мэндийн сайдын А/496, А/585 дугаар тушаалын дагуу коронавируст халдварын эрсдлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд ажилласан эрүүл мэндийн салбарын ажилтнуудыг урамшуулах зорилгоор олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 21.0 сая төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөөс 23.5 сая төгрөг, нийт 68.3 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна. Ирсэн санхүүжилтийг зарцуулах эрхийн хүсэлт нээлгэн зарцуулсан бөгөөд цалин шимтгэлд 26.4 сая, байр ашиглалтын зардалд 2.2 сая, эмийн зардалд 14.9 сая, хоол хүнсэнд 1.2 сая, багаж техник хэрэгсэлд 2.6 сая, мөнгөн тэтгэмжид 21.0 сая төгрөгийг тус тус зарцуулж тайлант оны эцэст үлдэгдэлгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Эрдэнэбулган сумын Эрүүл мэндийн төв нь тайлант жилд ковид-19 халдварын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээг нийт 120 хүнд үзүүлж ЭМДС-аас 64.7 сая төгрөгийн санхүүжилт нэхэмжилж гүйцэтгэлээр 51.0 сая төгрөг авч оны эцэст 13.7 сая төгрөгийн авлагатай тайлагнагдсан.

Эрдэнэбулган сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд ковид 19 цар тахалтай холбоотойгоор давхардсан тоогоор 88 иргэний ПСР-ийн шинжилгээг, 2037 иргэнд урьдчилан сэргийлэх үзлэгийг, 1570 иргэнд дархлаажуулалтын вакцинийг, 65 иргэнд хэвтэн эмчлүүлэх үйлчилгээг нийт 3760 иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлсэн байна.

Эрүүл мэндийн сайдын А/496, А/585 дугаар тушаалын дагуу коронавируст халдварын эрсдлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд ажилласан нийт 15 эрүүл мэндийн ажилтанд нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 21.0 сая төгрөгийг олгосон байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 11 үндсэн зорилтын хүрээнд 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 89.6 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 297.4 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 99.5 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэлэхэд Үүнд:

- Тус байгууллага нь тайлант онд 79.5 сая төгрөгийн бараа материал, 54.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хандив тусламжаар авч тайланд бүрэн тусгасан байна.

- Тайлант жилд коронавируст халдвараар өвчилсөн 55 иргэдэд гэрээр тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

Суудлын автомашин ашиглалтын хувьд: Тус байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 1 тээврийн хэрэгсэлд 9.6 сая төгрөгийн шатахуун, 2.0 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл зарцуулсан, орон тооны 1 жолоочтой, жолоочийн цалинд 18.0 сая төгрөгийг олгожээ.

Харин бусад судалгаанд хамаарах мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжууллаа. /Local.audit.mn сайтад шивсэн/

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Эрдэнэбулган сумын Эрүүл мэндийн төв нь тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс байршуулахаас 5 мэдээллийг хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагаын нийт 28 гүйлгээний 30.1 сая төгрөгийн мэдээллийг ил тод байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-6.10-д заасан “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ ...”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийг мэдээлэх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд цалингийн давтан тооцооллоор 0.2 сая төгрөгийн цалин илүү олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон, үндсэн хөрөнгөтэй холбоотой зөвлөмж өгч биелэлтийг бүрэн хангуулсан.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нэмэлт санхүүжилт, хандив тусламжийн зарцуулалтыг авч үзэх нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1.3 сая төгрөгийн зөрчил илэрсэнд төлбөрийн акт тогтоолоо.

4.1 Төлбөрийн акт тогтоох

Цалингийн давтан тооцооллоор дээд шатны төсөв захирагчийн шийдвэргүй 1.3 сая төгрөгийн илүү цагийн хөлсийг олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийг хэмнэлтийн Засгийн газрын 43 дугаар тогтоол болон Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Эрдэнэбулган ЭМТөв	1	1.3	0	0	1	1.3	0	0	0	0
	ДҮН	1	1.3	0	0	1	1.3	0	0	0	0
Нийцлийн аудитын асуудлаар											
	Эрдэнэбулган ЭМТөв	1	0	0	0	0	0	0	0	1	0
	ДҮН	1	0	0	0	0	0	0	0	1	0
	Нийт дүн	2	1.3	0	0	1	1.3	0	0	1	0